

Хараат бус аудиторын тайлан

ОЧИР УНДРАА ОМЗ ББСБ
ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ
2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон
Санхүүгийн тайлангийн аудит

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Очир Ундраа ОМЗ ББСБ ХХК-ийн Хувьцаа Эзэмшигчдэд

Санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Дүгнэлт

Бид, Очир Ундраа ОМЗ ББСБ ХХК-ийн (цаашид Компани гэх) 2024 оны 12 сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх ашиг алдагдал, бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тодруулга, тэмдэглэлээс бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, хавсаргасан санхүүгийн тайлангууд нь Компанийн 2024 оны 12 сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээ нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу, бүх материаллаг зүйлийг хамруулан, үнэн зөв толилуулагдсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын олон улсын стандарт (АОУС)-ын дагуу хийсэн. Эдгээр стандартын дагуу хүлээх хариуцлагаа энэхүү тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт харуулсан. Бид Нягтлан бодогчдын Ёс зүйн олон улсын стандартын зөвлөл (НБЁЗОУСЗ)-өөс гаргасан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Монгол улсын Аудитын тухай хуулиар санхүүгийн тайлангийн аудитад тавигддаг ёс зүйн шаардлагын дагуу компаниас хараат бус бөгөөд хууль болон НБЁЗОУСЗ-өөс гаргасан дүрмийн шаардлагын дагуу тавигддаг ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн. Бидний олж авсан аудитын нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж найдаж байна.

Аудитын гол асуудлууд

Аудитын гол асуудлууд гэдэг нь бидний мэргэжлийн үнэлэмжийн хүрээнд тайлант жилийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд юм. Санхүүгийн тайланд хийсэн аудитын хүрээнд эдгээр асуудлуудыг бүхэлд нь авч үзсэн

ба эдгээр асуудлын талаар тусад нь дүгнэлт гаргаагүй. Бид дараах асуудлыг гол асуудал гэж тодорхойлсон.

Харилцагчдад олгосон зээлийн эрсдэлийн сангийн хэмжилт

Компани Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2023 оны 12 сарын 08-ны өдрийн а/226/528 тоот хамтарсан тушаалаар батлагдсан “Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөх үүрэгтэй бөгөөд энэхүү журмыг мөрдсөнөөр Компани Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ыг анх удаа хэрэгжүүлж, санхүүгийн тайланг уг стандартад нийцүүлэн бэлтгэсэн.

Очир Ундраа ОМЗ ББСБ ХХК нь 2024 оны 08 дугаар сарын 29-ний өдөр Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг СТОУС-д нийцүүлэн шинэчлэн баталж, санхүүгийн тайланг СТОУС-д нийцүүлэх шилжилтийн үйл явцыг эхлүүлсэн болно. Тус бодлогын баримт бичигт СТОУС-9 Санхүүгийн хэрэглүүр стандартын хүрээнд тайлант жилийн эцэст хүлээгдэж буй зээлийн алдагдлыг тооцож болох зохицуулалтыг тусгасан хэдий ч санхүүгийн хөрөнгүүдийн хүлээгдэж буй алдагдлыг тооцохын тулд компанийн болон салбарын хувьд өмнөх жилүүдийн их хэмжээний өгөгдөлд суурилсан, тоон болон чанарын үзүүлэлтийг харгалзсан ялгаатай таамаглал болон үнэлэмжүүдийг ашигласан нарийн төвөгтэй дүн шинжилгээ хийх, эрсдэлийн үнэлгээний аргачлалыг боловсруулан батлуулах шаардлага үүссэн ба аудитын дүгнэлт гарах өдрийн байдлаар зээлийн ангилал, хүлээгдэж байгаа эрсдлийг тооцох арга аргачлалыг эцэслэн дуусгаагүй байсан.

Компанийн хувьд зээл ба зээлийн ангилал, хүлээгдэж буй алдагдлыг тооцоолох нь маш чухал учир үүнд ихээхэн анхаарал хандуулж байгаа бөгөөд компанийн удирдлага 2025 оны санхүүгийн жилд СТОУС-ыг бүрэн хэрэгжүүлж дуусгах төлөвлөгөөтэй байгаагаа мэдэгдсэн.

Тайлант жилд зээлийн ангилал болон зээлийн эрсдэлийн санг Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ)-ноос баталсан журамд заасан шалгуурын дагуу тооцоолсон бөгөөд тайлант жилийн эцсээр нийт 88,758,341.9 мянган төгрөгийн зээлийн үлдэгдэлд 8,669,829.7 мянган төгрөгийн эрсдэлийн сан байгуулсан.

Аудитын хүрээнд компанийн зээлийн ангилал болон хүлээгдэж буй алдагдлыг СЗХ-ны журмын дагуу тооцоолсныг үнэлэхэд материаллаг алдаа илрээгүй болно.

Хэрвээ одоогийн мөрдөж байгаа Хүлээгдэж байгаа зээлийн алдагдал тооцох арга аргачлал, тооцоололд материаллаг хэмжээний өөрчлөлт орвол 2025 оны санхүүгийн жилд СТОУС-д бүрэн шилжихтэй холбоотойгоор дараах стандартыг буцаан мөрдөх шаардлагатай. Үүнд:

- НББОУС 1 – “СТОУС-ыг анх удаа мөрдөх” стандарт;
- СТОУС 9 – “Санхүүгийн хэрэглүүр” стандарт;
- СТОУС 7 – “Санхүүгийн хэрэглүүр: Тодруулга” стандарт.

Санхүүгийн тайлангийн талаар Удирдлага болон Засаглах удирдлагын хүлээх үүрэг хариуцлага

Удирдлага нь СТОУС-ын дагуу эдгээр санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд мөн залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой

болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага Компанийн үйл ажиллагааг зогсоох юм уу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудаа гаргахдаа удирдлага тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлага хүлээдэг.

Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Бидний зорилго санхүүгийн тайлангууд нь бүхэлдээ залилан юм уу алдаанаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах, өөрийн дүгнэлтийг багтаасан аудиторын тайлан гаргахад байдаг. Үл үндэслэлтэй нотолгоо нь баталгааны өндөр түвшин боловч АОУС-ын дагуу хийгддэг аудит нь оршин байгаа материаллаг буруу илэрхийллийг цаг ямагт илрүүлж байна гэсэн амлалт өгдөггүй. Буруу илэрхийлэл нь залилангаас эсвэл алдаанаас үүсэж болох ба дангаараа нийлээд материаллаг болж эдгээр алдаа нь санхүүгийн тайлангууд дээр суурилан хэрэглэгчийн гаргах эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай гэж үзсэн үед материаллаг буруу илэрхийллийг авч үзнэ.

АОУС-ын дагуух аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн үнэлэмж ашиглаж аудитын ажлын явцад мэргэжлийн үл итгэх хандлагыг баримталдаг. Бид мөн:

- Залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж өөрсдийн дүгнэлтийнхээ үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын баримт нотолгоог олж авдаг. Залилангаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг. Учир нь залиланд хуйвалдаан, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг орхигдуулах явдлууд багтсан байж болно.
- Компанийн дотоод хяналтын үр ашигтай байдалд дүгнэлт өгөх зорилгоор бус тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитын ажилтай холбоотой дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын нийцэмжтэй байдал, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын үл үндэслэл, удирдлагын хийсэн тооцоолол болон холбогдох тодруулгыг үнэлдэг.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэхийг тодорхойлдог. Хэрэв материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл ийм тодруулга хийх нь

хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэлх олж авсан аудитын баримт нотолгоондоо үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, эсвэл нөхцөл байдал Компани тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжгүй болгоход хүргэж болно.

- Тодруулгыг багтаагаад санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлж санхүүгийн тайланд үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар гол гол ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг тодорхойлдог.

Бид бусад асуудлуудын дундаас аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа болон аудитын явцад тодорхойлсон дотоод хяналтын аливаа мэдэгдэхүйц доголдлыг багтаагаад аудитын илэрсэн томоохон асуудлуудаар засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдтэй харилцдаг.

Бид хараат бус байдлын тухай холбогдох ёс зүйн шаардлагуудад нийцсэн мэдэгдлээр засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийг хангадаг ба мөн бид тэдгээр хүмүүстэй бүх харилцаа холбоо болон шаардлагатай гэж үзвэл харуул хамгаалалт зэрэг бидний хараат бус байдлын хүрээнд бодолцож үзвэл зохих асуудлуудаар харилцдаг.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдтэй харилцсан асуудлуудаас тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн нөлөөтэй асуудлуудыг тодорхойлж тэдгээр асуудлаа аудитын гол асуудлууд гэж үздэг.

Хууль, дүрэм журмаар аливаа асуудлыг олон нийтэд мэдээлэхийг хориглосон эсвэл тун ховор тохиолдолд аудиторын тайландаа аливаа асуудлаар харилцах нь тухайн харилцаанаас хүртэх олон нийтийн үр өгөөжөөс илүү сөрөг үр дагавартай гэж үздэг учраас аудиторын тайландаа харилцахгүй байх нь зүйтэй гэж үзсэнээс бусад тохиолдолд тэдгээр асуудлыг аудиторын тайландаа тодорхойлдог.

Бусад мэдээлэл

Удирдлага нь бусад мэдээлэлд хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэл гэдэгт жилийн тайланд орсон мэдээллийг хамруулж ойлгох ба санхүүгийн тайлан болон манай аудитын тайлан нь бусад мэдээллийг хамрахгүй буюу бид үүнтэй холбоотой ямар нэгэн баталгаажуулалт хийгээгүй болно.

Бидний гүйцэтгэсэн санхүүгийн тайлангийн аудиттай холбоотойгоор бид бусад мэдээллийг уншиж танилцан, бусад мэдээлэл нь аудитлагдсан санхүүгийн тайлан болон аудитын явцад олж авсан аудиторын мэдлэгээс материаллаг зөрүүтэй эсэхийг тодорхойлох үүрэгтэй. Хэрэв бусад мэдээлэл нь материаллаг зөрүүтэй бол бид энэ тухай тайлагнах үүрэгтэй.

Очир Ундраа ОМЗ ББСБ ХХК-ийн 2024 оны жилийн тайлан нь энэхүү аудиторын тайлангаас хойш бидэнд танилцуулагдахаар хүлээгдэж байна. Хэрэв жилийн тайлантай танилцах үед бусад мэдээлэлд материаллаг буруу илэрхийлэл байна гэж үзвэл холбогдох арга хэмжээг дурдан бид засаглах эрх бүхий этгээдүүдэд мэдэгдэх үүрэгтэй.

Бусад асуудал

Энэхүү тайланг өөр ямар нэгэн зорилгоор биш, Монгол улсын Компанийн тухай хуулийн 94 дүгээр зүйлд заасны дагуу Очир Ундраа ОМЗ ББСБ ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн захиалгаар гүйцэтгэж, хувьцаа эзэмшигчдэд зориулан гаргасан. Бид энэхүү тайлангийн хүрээнд өөр аливаа гуравдагч этгээдийн өмнө хариуцлага хүлээхгүй болно.



Хаяг: Улаанбаатар хот 14240, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпын гудамж 7/3 байр, Centrum төв, 7 давхар 701 тоот.

Утас: 976-70150003, **И-мэйл:** info@moore-mongolia.mn

Ашиг алдагдал, бусад дэлгэрэнгүй орлогын тайлан

	Тод	Аудитлагдсан 2024 ₮'000	Аудитлагдсан 2023 ₮'000
Хүү болон түүнтэй адилтгах орлого	7	24,231,504	16,210,864
Хүүний зардал	8	(4,299,733)	(2,584,338)
Цэвэр хүүгийн орлого		19,931,771	13,626,526
Зээлийн эрсдлийн зардал	9	(2,364,007)	(2,227,589)
Зээлийн эрсдлийн зардал хассан цэвэр хүүгийн орлого		17,567,764	11,398,937
Хүүгийн бус орлого	10	1,146,576	430,353
Хүүгийн бус зардал	11	(4,754,494)	(4,070,319)
Татварын өмнөх ашиг		13,959,846	7,758,971
Орлогын татварын зардал	12	(2,497,086)	(991,295)
Тайлант жилийн ашиг		11,462,760	6,767,676
Бусад дэлгэрэнгүй ашиг			-
Нийт дэлгэрэнгүй ашиг		11,462,760	6,767,676



Санхүүгийн тайлангийн тодруулгууд нь энэхүү аудитлагдсан санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

Санхүүгийн байдлын тайлан

	Тод	Аудитлагдсан 2024 ₮'000	Аудитлагдсан 2023 ₮'000
ХӨРӨНГӨ			
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	13	3,248,200	4,203,547
Богино хугацаат хөрөнгө оруулалт	14	33,304	24,314
Харилцагчдад олгосон зээл /Цэвэр/	15	80,088,512	57,303,393
Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	16	1,470,529	1,000,373
Бусад авлага	16	1,190,139	386,054
Санхүүгийн хөрөнгийн дүн		86,030,684	62,917,681
Бусад санхүүгийн бус хөрөнгө	21	2,929,079	757,077
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	20	1,006,210	684,000
Үндсэн хөрөнгө	17	551,890	1,965,940
Биет бус хөрөнгө	18	220,993	169,113
Хөрөнгийн ашиглах эрх	19	68,358	-
Санхүүгийн бус хөрөнгийн дүн		4,776,530	3,576,130
НИЙТ ХӨРӨНГӨ		90,807,214	66,493,811
ӨР ТӨЛБӨР			
Итгэлцэлийн үйлчилгээний өглөг	22	27,126,556	21,856,850
Хуримтлуулж тооцсон үр шимийн өглөг	22	1,489,612	1,351,413
Зээл ба зээллэг	23	4,989,230	-
Түрээсийн өр төлбөр	24	74,213	-
Бусад санхүүгийн өр төлбөр	22	163,546	271,208
Санхүүгийн өр төлбөрийн дүн		33,843,157	23,479,471
Татварын өр төлбөр	24	603,127	578,429
Санхүүгийн бус өр төлбөрийн дүн		603,127	578,429
НИЙТ ӨР ТӨЛБӨР		34,446,284	24,057,900
ЦЭВЭР ХӨРӨНГӨ		56,360,930	42,435,911
ӨМЧ			
Хувьцаат капитал	25	5,000,000	2,500,000
Хуримтлагдсан ашиг (алдагдал)		50,675,737	39,234,977
Бусад нөөц	26	685,193	700,934
НИЙТ ӨМЧ		56,360,930	42,435,911

Санхүүгийн тайлангийн тодруулгууд нь энэхүү аудитлагдсан санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

Өмчийн өөрчлөлтийн тайлан

	Тод	Хувьцаат капитал ₮'000	Бусад нөөц ₮'000	Хуримтлагдсан ашиг ₮'000	Нийт өмч ₮'000
2023 оны 12 сарын 31-нээрх үлдэгдэл		2,500,000	684,733	32,507,762	35,692,495
Тайлант жилийн ашиг		-	-	6,767,676	6,767,676
Нийгмийн хөгжлийн санд хуваарилсан	26	-	40,461	(40,461)	-
Нийгмийн хөгжлийн сангаас зарцуулсан	26	-	(24,260)	-	(24,260)
2023 оны 12 сарын 31-нээрх үлдэгдэл		2,500,000	700,934	39,234,977	42,435,911
Тайлант жилийн цэвэр ашиг (алдагдал)		-	-	11,462,760	11,462,760
Нэмж гаргасан хувьцаа	25	2,500,000	-	-	2,500,000
Нийгмийн хөгжлийн санд хуваарилсан	26	-	22,000	(22,000)	-
Нийгмийн хөгжлийн сангаас зарцуулсан	26	-	(37,741)	-	(37,741)
2024 оны 12 сарын 31-нээрх үлдэгдэл		5,000,000	685,193	50,675,737	56,360,930



Санхүүгийн тайлангийн тодруулгууд нь энэхүү аудитлагдсан санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

Мөнгөн гүйлгээний тайлан

	Тод	Аудитлагдсан 2024 ₮'000	Аудитлагдсан 2023 ₮'000
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Татварын өмнөх ашиг		13,959,846	7,758,971
Тохируулга:			
Хөрөнгийн элэгдэл, хорогдол	17	332,539	238,998
Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз	17	482	-
Валютын ханшийн зөрүүний бодит бус гарз/ (олз), цэвэр	11	(282)	1,497
Хүүгийн зардал	8	228,930	109,536
ААБҮЦ-ээр хэмжигдэх санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийн (ашиг) алдагдал	10,11	(8,990)	10,041
ХОЗҮХХ-ийн бодит үнэ цэнийн олз	19	(322,210)	-
<i>Ажлын капиталын тохируулга:</i>			
Итгэлцлийн үйлчилгээний өсөлт/ (бууралт)	22	5,269,706	8,430,112
Итгэлцлийн үр шимийн өглөгийн өсөлт/ (бууралт)	22	138,199	289,947
Бусад өглөгийн өсөлт/ (бууралт)	22	(198,216)	192,893
Харилцагчдад олгосон зээлийн / цэвэр / (өсөлт) /бууралт	15	(22,785,119)	(14,722,794)
Зээлийн хүүгийн авлагын (өсөлт) /бууралт	16	(470,156)	(136,874)
Бусад авлагын (өсөлт) /бууралт	16	(804,085)	(236,527)
Бусад санхүүгийн бус хөрөнгийн (өсөлт) /бууралт	21	(745,073)	41,992
БЗЭБХ-ийн (өсөлт)/бууралт	16	-	(307,740)
Хуримтлагдсан ашгаас нийгмийн хөгжлийн санд зарцуулсан	26	(37,741)	(24,260)
Хүүгийн төлбөрт төлсөн	8	(228,929)	(109,536)
Төлсөн орлогын татвар		(2,381,839)	(738,545)
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		(8,052,938)	797,711
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Үндсэн хөрөнгө худалдан авсан	17	(234,309)	(131,995)
Биет бус хөрөнгө худалдан авсан	18	(111,113)	(23,868)
Худалдан авсан/ Борлуулсан хөрөнгө оруулалт	14	-	65,065
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		(345,422)	(90,798)

Санхүүгийн тайлангийн тодруулгууд нь энэхүү аудитлагдсан санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно

Мөнгөн гүйлгээний тайлан

	Тод	Аудитлагдсан 2024 ₮'000	Аудитлагдсан 2023 ₮'000
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Хүлээн авсан зээл	23	73,284,621	39,086,922
Зээлийн үндсэн төлбөрт төлсөн	23	(68,295,391)	(39,086,922)
Түрээсийн өр төлбөрийн үндсэн төлбөрт төлсөн	19	(46,499)	-
Хувьцаа гаргалтаас хүлээн авсан	25	2,500,000	-
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		7,442,731	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр өсөлт/ (бууралт)		(955,629)	706,913
Валютын ханшийн өөрчлөлтийн нөлөө	11	282	(1,497)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		4,203,547	3,498,131
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		3,248,200	4,203,547



Санхүүгийн тайлангийн тодруулгууд нь энэхүү аудитлагдсан санхүүгийн
тайлангийн салшгүй хэсэг болно.